



12

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 4/07

Номгон

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн онцгой комиссын даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тушаалын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сумын хэмжээнд цасан бүрхүүл тогтсон, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулж хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх зорилгоор “Зудын эрсдэлийн үед ажиллах шуурхай штаб”-ыг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох дээд шатны байгууллага, сумын Засаг дарга, иргэдийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаарх мэдээллээр хангаж нэгдсэн зохион байгуулалттай ажиллахыг шуурхай штабын дарга (С.Батцэрэн)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д даалгасугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР

Баянхонгор сумын Засаг даргын *д/д 3* оны
01 дүгээр сарын *09* -ний өдрийн *4/07*
 дугаар захирамжийн хавсралт

ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Шуурхай штабын дарга

С.Батцэрэн

(Засаг даргын Орлогч)

Гишүүд:

О.Дашдаваа

(Боловсрол соёл, урлагийн асуудал хариуцсан

мэргэжилтэн)

О.Цэндмаа

(Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спортын

асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Сувданцэцэг

(Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн асуудал

хариуцсан мэргэжилтэн)

Т.Оюунгэрэл

(Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Т.Дагдмаа

(Орлого хариуцсан ажилтан)

Ө.Цэвээнбат

(Тархвар зүйч)

Л.Батцэцэг

(Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч)

А.Адъяадолгор

(Бэлчээр, тэжээл, газар тариалангийн асуудал

хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Гүндсамба

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал

хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

(Багийн Засаг дарга нар)

(Багийн бүртгэл мэдээллийн ажилтнууд)

Нарийн бичгийн дарга:

Б.Баасанжаргал

(Мал аж ахуйн, үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент,

малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)